



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
2009





Санхүүгийн зохицуулах хороо 2009 оны үйл ажиллагааныхаа тайланг Танд өргөн барьж байна.

2009 он Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт дэлхийн улс орнуудад бий болсон санхүү, эдийн засгийн хямрал нөлөөлсөн жил байлаа.

Хэдийгээр хямралын жил байсан ч хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг Хорооны хяналт зохицуулалтад хамаарах банкнаас бусад санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, уг салбаруудын цаашдын тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэх чухал хүчин зүйлүүдийн нэг болох эрх зүйн орчныг бий болгоход хороо гол анхаарлаа хандуулж ажилласан болно.

Зохицуулалтын хүрээний салбаруудад хамаарах гол дүрэм, журам, заавруудыг батлан гаргаж дууссан нь энэ оны гол ажлуудын нэг байлаа.

2009 онд үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг салбаруудын үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн суурь болсон гол хуулиудын төслийг боловсруулсан бөгөөд 2010 онд эдгээр хуулиудыг батлуулахаар хичээн ажиллах болно.

Дэлхийн банкны 2009 оны "Монгол Улс дахь компанийн засаглалын үнэлгээний тайлан"-гаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу "Компанийн засаглалын кодекс"-т нэмэлт өөрчлөлт оруулан, мөн "Даатгалын компанийн засаглалын кодекс"-ыг батлан мөрдөж байгаа. Цаашид бид компанийн засаглалыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээ 2010 онд үргэлжлүүлэн илүү үр дүнтэй ажиллахын төлөө хичээх болно.

Монгол Улсын банк давамгайлсан санхүүгийн зах зээлийн бүтцийг өөрчлөх, тэр тусмаа олон улсын нийтлэг чиг хандлагад нийцсэн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг шинэ шатанд гаргах тал дээр Санхүүгийн зохицуулах хорооны үүрэг хариуцлага өндөр гэдгийг ойлгож байгаа бөгөөд 2010 онд энэ салбарт онцгой ахиц дэвшил гаргахын төлөө ажиллана.

Санхүүгийн зах зээл дээр ажиллаж буй хуулийн этгээд, мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх, тэдний мэргэжлийн төвшин, ёс зүй, санхүүгийн сахилга, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, бүх нийтийн санхүүгийн боловсролын төвшинг дээшлүүлэх, хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг Хорооны анхаарлын төвд байсаар ирсэн асуудлуудыг үргэлжлүүлэн анхаарч 2010 оны үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

Хүндэтгэсэн,

Дашдондовын Баярсайхан

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Санхүүгийн Зохицуулах Хороо нь **Улс орныхоо санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлын баталгаа байна”** эрхэм зорилтын хүрээнд:

1. **Эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Хорооноос шалтгаалах бүхий л арга хэмжээг авч, салбарын гол хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах, хэлэлцүүлж батлуулах**
2. **Гадаад хамтын ажиллагааны бодлого чиглэлийг боловсруулж IOSCO, IAIS -ийн гишүүн орнуудын хүрээнд мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх Олон талт санамж бичигт нэгдэхэд чиглэсэн арга хэмжээг Хорооноос авч хэрэгжүүлэх**
3. **Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийн зайны болон газар дээрх хяналтын чанарыг дээшлүүлэн хөрөнгө оруулагч, даатгуулагчид, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх**
4. **Компанийн засаглалын зарчмыг түгээн сурталчлах, хэрэгжилтийг хангах талаар бодитой ажил хийх**
5. **Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндсэн гарын авлага боловсруулж хэвлүүлэх, түгээн сурталчлах үндсэн 5 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д “Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна” гэсэн заалтын дагуу өөрийн харьяалах салбарын үйл ажиллагааг зохицуулах цаг үеийн тулгамдсан 282 асуудлыг 15 удаагийн ээлжит, 2 удаагийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 281 тогтоол, 23 тэмдэглэл гаргаж, олон нийтэд тухай бүр мэдээлэн, шийдвэрийн биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Хорооны нэг удаагийн хуралдаанд дунджаар 24 асуудал хэлэлцэгдэж байгаа нь зохицуулалтын салбарын хүрээнд шийдвэрлэвэл зохих нилээдгүй асуудал байгааг харуулж байна.

Хорооны Ажлын алба нь Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газар, Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар, Тамгын газар, Эрх зүйн хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Дотоод хяналтын алба гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан.

1. **Эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Хорооноос шалтгаалах бүхий л арга хэмжээг авч, салбарын гол хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах, хэлэлцүүлж батлуулах зорилтын хүрээнд:**

Энэхүү зорилтын хүрээнд Хороо нь өөрийн зохицуулалтын салбарт эрх зүйн таатай орчин бүрдүүлэх шаардлагатай дүрэм, журам, зааврыг боловсруулж, батлан мөрдөх ажлыг төлөвлөн хэрэгжүүллээ.

“Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын 2009 оны 22 дугаар тогтоол, УИХ-ын ЭЗБХ-ны 2009 оны “Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хороо “УИХ, ЭЗБХ-ны тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай” 63 дугаар тогтоолыг 2009 оны 3 дугаар сарын 26-ны өдөр гаргасан. Уг тогтоолоор Хорооноос хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан бөгөөд УИХ, ЭЗБХ-ны дээрх тогтоолууд болон Хорооны 63 дугаар тогтоолын биелэлтийн талаар УИХ, Засгийн газар, Үндэсний хөгжлийн шинэтгэлийн хороонд хүргүүлж ажилласан.

Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний нэг хэсэг болгож хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид болох андеррайтер, брокер, дилерийн компаниуд болон хувьцаа эзэмшигчдэд санхүүгийн бодитой дэмжлэг үзүүлэх зорилгоор Хороо 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдөр 35 дугаар тогтоол гаргасан. Уг тогтоол ёсоор арилжааны гүйлгээнээс брокер, дилерийн компаниудын олсон шимтгэлийн 10 хувийг Хороонд төвлөрүүлж байсныг 2009 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хугацаагаар зогсоохоор шийдвэрлэсэн. Энэ арга хэмжээний хүрээнд 8 531 960 төгрөгийн бодитой дэмжлэг үзүүлсэн болно.

Хороо 2009 онд Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагыг заавал даатгах даатгалын тухай хууль, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг хуулийн төслүүдийн анхны хувилбарыг боловсруулж ажлын хэсэгт ажилласан.

Эдгээр хуулиудаас гадна Сангийн яам, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг бусад байгууллагуудтай хамтран Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг хуулиудын төслийг боловсруулах ажлын хэсэгт идэвхтэй ажилласан.

**Тайлант онд Санхүүгийн зохицуулах хороо дараах зохицуулалтын гол журмуудыг боловсруулаад байна. Үүнд:**

1. “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журмыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталсан.

2. “Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай” журмыг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран боловсруулж баталсан.

3. Даатгалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасны дагуу даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаатай холбоотой журмыг шинээр боловсруулсан.

4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон эрх бүхий байгууллагаас баталж гаргасан мөрдөгдөж буй журам, зааврын хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээр цахим төлбөр тооцооны үйлчилгээг Монгол улсад шинээр нэвтрүүлэх, энэ хэлбэрээр гүйцэтгэх боломжтой гэж үзэн “Цахим мөнгөний үйлчилгээний түр журам”-ыг баталж мөрдөж байна.

5. Санхүүгийн салбарын зээлийн эрсдэлийг бууруулах, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төрөөс дэмжих ажлын хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт оролцож ажилласан.

б. Валютын арилжааны үйл ажиллагаанд оролцогчдыг эрсдэлээс хамгаалах, төрийн зохицуулалтыг оновчтой болгох зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуультай нийцүүлэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг батлан цаашид гадаад валютын арилжааг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий ББСБ эрхэлж байхаар зохицуулсан.

Иргэд, даатгуулагчдаас даатгалын зах зээлд итгэх итгэлийг бататгах зорилтын хүрээнд даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж санхүүгийн чадавхийг нь бэхжүүлэх зорилгоор “Даатгалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан УИХ-аар батлуулж, уг хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд даатгалын байгууллагуудын дүрмийн сангийн доод хэмжээг 2010 онд хоёр дахин нэмэгдүүлэх тухай Хорооны шийдвэр гаргасан бөгөөд энэ нь уг зах зээлийг бэхжүүлэх, өргөжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Төрийн зүгээс явуулж байгаа даатгалын зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсад “заавал даатгалын тогтолцоо”-г бий болгон нэвтрүүлэхэд анхаарч, эхний ээлжид жолоочийн хариуцлагыг заавал даатгах даатгалын тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангалаа.

Монгол Улсад үнэт цаасны зах зээл үүсч хөгжсөнөөс хойших хугацаанд уг зах зээлийн талаар төрөөс баримталж ирсэн бодлого, чиглэлийг тодорхой болгох, хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд хөгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэл”-ийг баталж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулаад байна.

**2. Гадаад хамтын ажиллагааны бодлого чиглэлийг боловсруулж олон улсын үнэт цаасны хороодын байгууллага (IOSCO), олон улсын даатгалын хяналт шалгагчдын холбоо (IAIS) -ийн гишүүн орнуудын хүрээнд мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх Олон талт санамж бичигт нэгдэхэд чиглэсэн арга хэмжээг Хорооноос авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**

Тайлант онд Санхүүгийн зохицуулах хорооны “Гадаад бодлогын үндсэн чиглэл” –ийн төслийг Хорооны хуралдаанаар хэлэлцэн баталж, хамтын ажиллагааг хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны чиглэлээр хөгжүүлэх нь зүйтэй гэж тогтлоо.

Тайлант онд Үнэт цаасны холбоодын олон улсын байгууллага (IOSCO)-ын Санамж бичгийн “Б” жагсаалтад нэгдэн ороход холбоотой бэлтгэл ажлыг бүрэн хангаж Санамж бичгийн “Б” хавсралтад нэгдэн орсон явдал нь Хороо үүсгэн байгуулагдсанаас хойш өнгөрсөн 3 жилд гадаад хамтын ажиллагааны тал дээр хийж гүйцэтгэсэн томоохон ажлын нэг болсныг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Олон Улсын даатгалын хяналт шалгагчдын холбоо (IAIS)-той хамтран ажиллах тухай олон талт санамж бичгийн төслийг эцэслэн боловсруулаад байна.

Япон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас Санхүүгийн зохицуулах хорооны чадавхийг сайжруулах ажлын хүрээнд хорооны ажилтнуудын чадавхийг сайжруулах төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд төслийн санхүүжүүлэх шийдвэр нь 2010 оны 2 дугаар улиралд гарах юм.

Дэлхийн Банк(WB)-тай тогтоосон уламжлалт харилцааг дэмжиж, Санхүүгийн зохицуулах хорооны чадавхийг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн тайлагнал аудит, үнэлгээний чанарын хяналтын газрын чадавхийг бэхжүүлэх зорилгоор төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Сангийн яамаар дамжуулан өргөн бариад байна.

Олон Улсын Санхүүгийн корпораци (IFC/WB)-тай ажлын шугамаар тогтсон уламжлалт харилцааг

дэмжиж, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоодын судалгааг хүргүүлж, Компанийн Засаглалын Хөгжлийн төв байгуулагдаж байгаатай холбогдуулан Компанийн засаглалыг сайжруулах төслийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Олон Улсын Валютын Сан(IMF)-тай ажлын шугамаар тогтсон уламжлалт харилцааг дэмжиж, Санхүүгийн зохицуулах хороонд чадавхийг сайжруулах төслийн хүрээнд Үнэт цаас, Бичил санхүү, Даатгалын салбарт олон улсын зөвлөхүүд тус хороон дээр ажиллаж, эрх зүйн орчин, салбарын хөгжлийн бодлогын чиглэлээр зөвлөмж гаргаж, хорооны ажилтнууд болон мэргэжлийн оролцогч нарт сургалт, семинар зохион явууллаа.

Гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах зорилтын хүрээнд БНХАУ, БНКАЗУ-тай санамж бичиг зурж, Хон-Конг, БНСУ, Польшийн Санхүүгийн Зохицуулах Хороодтой хамтран ажиллах Санамж бичгийг албажуулах ажил үргэлжлэн хийгдэж байна.

Азийн хөгжлийн банк(ADB)-наас хэрэгжүүлэх техникийн туслалцааны 2 дугаар шатны төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус төслийн багийнхантай хамтран ажиллаж, хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Хөрөнгийн зах зээлийг сурталчлах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт сургалтыг 2 хот, 5 аймагт зохион байгууллаа. Уг төслийн санхүүжилтээр Хөрөнгийн зах зээлийн тухай хууль, тогтоомжийн эмхтгэл, Хөрөнгийн зах зээлийн тухай гарын авлага, Монгол Улсын Компанийн засаглалын тухай кодекс, СЗХ-ны тухай танилцуулга, Хөрөнгийн зах зээлийн тухай сурталчилгааны плакат зэрэг таван багц материалыг хэвлүүлж тараасан байна.

Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд СЗХ-ны Мэдээллийн технологийн бүтэц, цаашдын зорилтыг тодорхойлж, мэдээллийн технологийг бэхжүүлэх талаар бусад төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах шийдэлд хүрлээ.

ОУВС-аас 2008-2009 онд хэрэгжүүлж буй хорооны чадавхийг дээшлүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах ажлын хүрээнд Олон Улсын валютын сангийн зөвлөх даатгалын чиглэлээр тус хороонд томилогдон ажиллаж, хийгдсэн уулзалт, сургалт нь даатгалын зах зээлийн мэргэжлийн оролцогч нарт өгөөжтэй арга хэмжээ болсон.

Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Даатгалын салбарын эрх зүйн орчныг сайжруулах” төслийн хэрэгжилт үргэлжилж байгаа бөгөөд тухай бүрт нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

**3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийн зайны болон газар дээрх хяналтын чанарыг дээшлүүлэн хөрөнгө оруулагч, даатгуулагчид, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**


Хорооноос тайлант жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үндсэн 5 зорилтын хамгийн гол зорилт буюу Хорооны эрхлэх ажлын хүрээнд хамаарагдах салбаруудын үндсэн үйл ажиллагааг дараах байдлаар танилцуулж байна.

## А.ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2009 оны эцсийн байдлаар Хөрөнгийн зах зээл дээр арилжаа эрхлэх байгууллага 1, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага 1, брокер, дилерийн 48 компани, 353 хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Хороо тайлант жилд брокер дилерийн 7 компанид үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 5 компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 7 компанийн тусгай зөвшөөрлийг сэргээж, 2 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон бүртгэлтэй үнэт цаасны тоо



Эдгээр 353 ХК-ийн 23 нь 100 хувь төрийн өмчит ХК, 28 нь төрийн өмчийн оролцоотой ХК байгаа бөгөөд үлдсэн 302 ХК-ийн нилээд хэсэг нь үнэн хэрэгтээ дампуурч, ямар ч хөрөнгөгүй болсон, бараг тал нь дөнгөж зардлаа нөхөх төдий үйл ажиллагаа явуулдаг, идэвхтэй арилжигддаг үнэт цаасны тоо цөөн байгаа нь зах зээлийн хөрвөх чадварт муугаар нөлөөлсөөр байгаа төдийгүй хөрөнгө оруулагчдын эрх ашиг зөрчигдөж байна.

Нийт компанийн хувьцааны дийлэнх хэсэг нь нэгдмэл сонирхол бүхий цөөн хэдэн хүний гарт төвлөрснөөс хувь нийлүүлэгчдийнхээ жил бүрийн ээлжит хурлыг хийх, санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлэх, олон нийтэд хүртээл болгох, ногдол ашиг хувиарилах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхгүй байх зэрэг үйлдлүүд байсаар байна.

Нөгөө талаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийнхээ талаар бүрхэг ойлголттой олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаа нь эдгээр компаниудыг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх шалтгааны нэг болж байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг эрхэлдэг төрийн өмчит “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” /ҮЦТТХТ/ ХХК-д тайлант оны эцсийн байдлаар нийт 559,464 хувьцаа эзэмшигчдийн харилцах данс байгаагаас харахад:

“ҮЦТТТХТ” ХХК-ийн дансны  
судалгаа

2009.12.31.

Нээгдсэн		Нээгдээгүй		Нийт
443,928		79%		115,536
21%		559,464		
Иргэн		ААНэгж		
Монгол	Гадаад	Монгол	Гадаад	
442,575	627	659	67	

Үүний зэрэгцээ жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмчлөх эрхээ хэрэгжүүлэх идэвх ч туйлын хангалтгүй байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр нээгдэх ёстой нийт данснаас 21 хувь буюу 115,536 данс нээгдээгүй байгаа явдал юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид иргэн, ААН-ийн нийт 559,464 данс бүртгэлтэй байгаа хэдий боловч давхардсан тоогоор хувьцаа эзэмшигчдийн 0.3 хувь буюу 1800 орчим иргэн, хуулийн этгээд (Төрийг оролцуулан) дээр бүртгэлтэй үнэт цаасны 1 ба түүнээс дээш хувь буюу нийт бүртгэлтэй хувьцааны 2.7 тэрбум ширхэг нь, өөрөөр хэлбэл 84 % нь төвлөрсөн байна.

Тайлант онд дээрх хууль бус үйлдлүүдийг таслан зогсоохтой холбоотой шаардагдах дүрэм, журмыг нэн тэргүүнд боловсруулан баталж мөрдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлд оролцогчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах гол зорилтыг хэрэгжүүллээ.

Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаас (Ипотек) гарган дотоод, гадаадын хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, Монгол улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгох ажлын эхлэл тавигдлаа.

Тайлант онд “Монголын ипотекийн корпораци” ХХК зээлийн хөрөнгөөр баталгаажуулан үнэт цаас гаргаж, шинэ хямд эх үүсвэр татах замаар ипотекийн анхдагч зах зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбох, улмаар зээлийн хүүг бууруулж хүн амын орон сууцны хэрэгцээг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор нийтэд санал болгон гаргах 2,5 жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй, 3,5 жилийн хугацаатай, жилийн 14,3 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, жилийн 14,5 хувийн хүүтэй нэг бүр нь 1 000 000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 25 000 /хорин таван мянга/ ширхэг “МИК” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэх асуудлыг Хороонд тавьж шийдвэрлүүлсэн байна. Өнөөгийн байдлаар Худалдаа хөгжлийн банк, Капитрон банкууд 3 төрлийн нийт 5700 ширхэг бондыг тэнцүү хэмжээний зээлийн багцаар сольж худалдан авсан байна.

Хороо нь хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс Анод банкинд үнэт цаасаа нийтэд санал болгон гаргах зөвшөөрлийг олгосон хэдий ч хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг эрхэмлэн “Анод банк” ХК-ийн хувьд цаашид авах арга хэмжээний талаар өөрийн байр суурь, санал бодлоо илэрхийлж ажиллалаа.

Нэн тэргүүнд Монгол Улсын Засгийн Газрын 2006 оны 155 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшигч нарын ногдол ашгийн болон хувьцаа худалдсаны мөнгө болох дампуурсан банкуудад байршуулж байгаад эрсдэлд орсон мөнгөний үлдэгдэл 560 сая төгрөгийг иргэдэд олгохоор шийдвэрлэсэн. Үүнээс 427 сая төгрөг 2006 /370 сая төгрөг/, 2008 /57 сая төгрөг/ онуудад хүлээн авснаас 2006 /81,8 сая/, 2007 /239,5 сая/, 2008 /61 сая/, 2009 /44,7 сая/ онуудад бүрэн тарааж дууссан бөгөөд одоогийн байдлаар 133 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангийн яамнаас үлдэгдлийг шийдвэрлэсэн тохиолдолд энэ мөнгийг 2010 онд бүрэн тарааж дуусгана. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд үнэт цаасны

төлбөр тооцооны байгууллага болох “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай онцгой хүчин чармайлт гаргаж, өндөр үр дүнтэйгээр асуудлыг зохион байгуулан ажиллаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хорооны үнэт цаасны салбар хариуцсан улсын байцаагч нар хувьцаа эзэмшигч, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдолтой асуудлаар нийт 134 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.


Үүний зэрэгцээ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, тавьсан шаардлагыг хэрэгжүүлдэггүй албан тушаалтан болон аж ахуйн нэгжид нийт 2,830,000 төгрөгийн захиргааны шийтгэл ногдуулжээ.

Тайлант онд хувьцаа эзэмшигчдийн хувьцааг зөвшөөрөлгүйгээр биржийн арилжаагаар худалдаж, завшсан үйлдлүүдийн хохирлыг барагдуулах тухай 341 ширхэг гомдол, өргөдлийг хүлээн авч Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэсэн ба энэ нь хороонд ирсэн нийт өргөдөл гомдлын 77,3%-ийг эзэлж байна.

Үнэт цаасны бүртгэлд 2009 оны төгсгөлд 5 төрлийн 887,272 ширхэг компанийн бонд болон 353 ХК-ийн 2.9 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагийн дийлэнхийг төрийн болон орон нутгийн өмчит 51 ХК-ийн 1.8 тэрбум ширхэг хувьцаа эзэлж байна.

Тайлант оны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт 255 удаагийн арилжаагаар 13,956 хэлцэл хийгдэж 89.9 сая ширхэг үнэт цаасны /хувьцаа/ арилжигдаж, 23.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.6 дахин багассан нь санхүү, эдийн засгийн хямралтай холбогдон тайлбарлагдаж байна.

Арилжаалагдсан үнэт цаасны хэмжээ болон төрлийн бүтцийг графикаар харуулбал:





Өмнөх оны эцэст 515,872 сая төгрөгт хүрч байсан үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2009 оны эцэст 620,750 сая төгрөгт хүрч, 104,878 сая төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна.



Үнэт цаасны зах зээлийн өсөлт, бууралтыг харуулдаг гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн дундаж үзүүлэлт 2009 оны эхэнд 5,583.2 нэгж байсан бол оны эцсээр 6,190.9 нэгж болж 606.7 нэгжээр өссөн нь хувьцааны арилжааны идэвхи бага зэрэг нэмэгдсэн болон тухайн индексэд багтдаг хувьцаат компаниудын хувьцааны ханш өссөнөөс шалтгаалжээ. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 7937.13 нэгж байсан байна.

Топ-20 индексийн дундаж





Ногдол ашиг тараах ХК-ийн тоо болон тарааж буй ногдол ашгийн хэмжээ 2005-2008 оны хооронд тогтвортойгоор өсөж байсан бол 2009 онд 3.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

**ХК-иудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах талаар.** Оны эхэнд бүртгэлтэй байсан нийт 376 ХК-иас ээлжит хурлын тухай мэдэгдэл, хурлын материалыг Хороонд ирүүлээгүй 190 ХК-ийн нэрсийг хувьцаа эзэмшигчид, харилцагч байгууллагуудад удирдлагын нь бүрэн эрх дуусгавар болсон талаарх мэдээллийг “Өдрийн сонин”-гоор олон нийтэд мэдээлсэн болно.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудад зайны хяналт тавьсан талаар болон ХК-иудын 2008 оны жилийн эцсийн тайлан, 2009 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын 2008 оны жилийн эцсийн тайлан, 2009 оны бүх улирлуудын санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэн, мэдээллийн сан бүрдүүлсэн. Санхүүгийн тайланд үндэслэн зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийлээ.

Хороо “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ыг батлан сан бүрдүүлэх ажил үргэлжилж байна.

Өнөөгийн байдлаар уг мэдээллийн сан бүртгэлтэй ХК, мэргэжлийн оролцогчдын хувийн хэрэг, санхүүгийн тайлангийн нэгтгэл, 5% болон хяналтын багц эзэмшигч, нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл, газар дээрх үзлэг шалгалтын тайлан зэргээс бүрдэж байгаа болно.

## Б.БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн байгууллагын /цаашид ББСБ гэх/ үйл ажиллагааны тогтвортой байдлыг төлөвшүүлэх, санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор зохицуулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эрх зүйн баримт бичгүүдийг олон улсын жишиг, стандартад нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулах замаар эрсдэлд тулгуурласан хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгож, тус салбарын хөгжил, цаашдын тогтвортой байдлын үндэс суурийг бэхжүүлэх алхмууд хийгдээд байна.

Тайлант онд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, бичил санхүүгийн зуучлал, цар хүрээ, хүртээмж, өрсөлдөөнийг дэмжиж, оролцогч мэргэжлийн байгууллагуудын ашигт ажиллагааны төвшин, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгжилтийг хангуулах чиглэл хяналт тавьж ажиллалаа.

Хороо тайлант онд 56 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, нэр бүхий 3 ББСБ-д үйл ажиллагааны төрлийг нэмж, нэр бүхий 8 ББСБ-ын үйл ажиллагааны зарим төрлийг хүчингүй болгож, 2 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байна.

ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг хянаж, нийт 71 ББСБ-ийн холбогдох өөрчлөлтийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлэх зорилгоор салбар байгуулах шийдвэр гаргаж, салбар байгуулах, оноосон нэрээ өөрчлөх тухай хүсэлтийг хянаж 6 ББСБ-д 7 салбар нээх, үйл ажиллагаа нь зогсонги, алдагдалтай ажиллаж буй 1 ББСБ-ийн салбарыг татан буулгах, 2 ББСБ-ын оноосон нэрийг өөрчлөх шийдвэр тус тус гарсан байна.

Төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчинг тодорхой болгож валют солих цэгийн хяналт, зохицуулалтыг цэгцлэх, валютын арилжааны үйл ажиллагаанд оролцогчдыг эрсдэлээс хамгаалах зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуультай нийцүүлэн "Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Хорооны шийдвэр гарч, цаашид гадаад валютын арилжааг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий ББСБ эрхэлж байхаар зохицуулж, холбогдох арилжааны мэдээ, тайлан, нэгтгэл гаргах, мэдээлэх арга механизмыг тодорхой болгоход чиглэн ажиллалаа.

Энэхүү ажлын хүрээнд 24 хуулийн этгээдийн валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоод байна.

Дэлхийн банкны "Тогтвортой амьжиргаа төсөл"-ийн Бичил санхүүгийн хөгжлийн сангийн бөөний зээлд хамрагдахаар тендерт шалгарсан нэр бүхий 17 ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээ, энэхүү тендерт шалгарсан 4 ББСБ-ын зээлийн чанарт БСХС-ийн төлөөлөл болон Хорооны хянан шалгагч, улсын байцаагч нарын хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хорооны хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 38 ББСБ-д газар дээрх иж бүрэн хяналт, шалгалтыг, БСГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий /хуучнаар ВСЦ/ 61 ББСБ, Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг 3 ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх үзлэг, шалгалтыг хийж гүйцэтгэж, холбогдох арга хэмжээг авсан.

Шалгалтаар илэрсэн зөрчилд нийт 12 ББСБ-д 17.3 сая төгрөгийн захиргааны шийтгэвэр - ногдуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгаврыг Улсын байцаагчийн албан шаардлага, тайлангаар өгч, хэрэгжилтийн байдалд нь хяналт тавихын зэрэгцээ тухай бүр зөвлөгөө өгч ажиллалаа.

Тайлант онд ББСБ-ын санхүүгийн тайлан, тэнцлийг улирал бүр хүлээн авч, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байдалд дүн, шинжилгээ хийн, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар холбогдох үүрэг даалгавар, зөвлөгөөг давхардсан тоогоор нийт 497 тайлангийн хариугаар өгч ажиллалаа.

ББСБ-уудын ирүүлсэн улирал бүрийн санхүүгийн тайлан, тэнцлийг нэгтгэн, системийн нэгтгэлийг хийж, салбарын статистик дүн шинжилгээ, үнэлэлт, дүгнэлтийг хийсэн.

Хороо Зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталж гаргасан журмыг мөрдөж ажиллаагүй 15 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1-3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн ба түдгэлзүүлсэн хугацаандаа үүрэг даалгаврыг биелүүлсэн нэр бүхий 7 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээгээд байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлээгүй, түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгавраа биелүүлээгүй 4, өөрсдийн хүсэлтийн дагуу 7, нийт 11 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.


**Зах зээлийн өнөөгийн байдал:**

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 177 ББСБ-ын 150 нь Улаанбаатар хотод, 27 нь орон нутагт бүртгэлтэй, 9 нь Япон, БНСУ, Итали, АНУ, ОХУ зэрэг орнуудын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай байна.

Тайлант онд ББСБ-дын салбар, нэгжийн тоо 58, хувь нийлүүлэгчдийн тоо 497, ажиллагсдын тоо 746-д хүрсэн ба давхардсан тоогоор 108.3 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлжээ.

ББСБ-ын активын бүтцийн судалгаа /тэрбум төгрөгөөр/

**1. Нийт актив**



■ Нийт актив	2.9	23.4	44.1	18.9	28.7	38.4	69.2	66.4	78.5	96.5
■ Зээл	1.5	13.2	36.0	11.8	17.6	19.9	30.5	35.4	46.5	55.5
■ Мөнгөн хөрөнгө	0.9	5.7	4.8	4.5	8.2	14.4	19.1	17.9	20.1	31.0
■ Эргэлтийн бус хөрөнгө	0.5	1.3	2.1	1.5	2.1	3.4	11.9	4.9	4.1	4.1

ББСБ-дын нийт актив 96.5 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт активын 2.2 хувьтай тэнцэж байна.

Тайлант хугацаанд ББСБ-ын өөрийн болон бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өссөнтэй холбоотойгоор нийт эх үүсвэр нэмэгдсэнээр нийт актив өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өссөн. ББСБ-ын нийт активт зээлийн өрийн үлдэгдэл 57.5 хувь, мөнгөн хөрөнгө 32.2 хувь, эргэлтийн бус хөрөнгө 4.3 хувийн тус тус эзэлж байна.

## 2. Зээлийн багцын чанар



Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 8.9 хувь байгаа нь ББСБ-уудын зээлийн багцын чанар системийн хэмжээгээр сайн, харин 3.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан нь чанаргүй зээлийн 66.3 орчим хувьтай тэнцэж байгаа үзүүлэлттэй байна.

## 3. Зээлийн хүүгийн төвшин



Банк, санхүүгийн байгууллагуудын хооронд өрсөлдөөн эрчимтэй өрнөж, зээлийн хүүгийн төвшин тогтвортой буурч байсан ч дэлхийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас үүдэлтэй дотоодын инфляцын төвшин өссөнтэй уялдуулан 2008 онд өссөн бөгөөд 2009 онд зээлийн хүүгийн төвшин буураагүй болноо.

#### 4. Өөрийн хөрөнгө, дүрмийн сан




ББСБ-ын нийт өөрийн хөрөнгө 74.8 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын эзэмшигчдийн өмчийн 32.5 хувьтай тэнцэж байна. Харин өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 5.8 хувь байна.

ББСБ-ын дүрмийн сан болон ашгийн нийт хэмжээ тасралтгүй өсч байгаатай холбоотойгоор өөрийн хөрөнгө 2008 оны эцсээс 26.5 хувиар өссөн ба өөрийн хөрөнгийн 88.8 хувь нь ББСБ-ын дүрмийн сангаас бүрдэж байна.

#### 5. Бусдаас татсан эх үүсвэр

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ




Тайлант хугацаанд ББСБ-дын нийт бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 2008 оны эцсээс өсч, нийт эх үүсвэрийн 18.5 хувьд хүрсэн байна.

Энэ нь Хорооны 2008 оны 169 дүгээр тогтоолын дагуу ББСБ-ууд дүрмийн сангийн хэмжээгээ нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

## 6. Ашигт ажиллагаа

ББСБ-ЫГ ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГ  
/тэрбум төгрөгөөр/



ББСБ-дын үйл ажиллагаа идэвхжиж, цар хүрээ өргөжсөнтэй уялдан орлогын төвшин нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 13.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт орлогын өсөлтийн голлох шалтгаан нь үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн болон хүүгийн бус орлого /үүнээс: гадаад валютын арилжааны орлого, итгэлцлийн үйлчилгээний орлого, мөнгөн гуйвуулгын орлого, үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого/ байна.

Харин зардлын төвшингийн өсөлтийн хурдац харьцангуй өндөр буюу өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 11.5 тэрбум төгрөгөөр өсчээ. Энэ нь гадаад валютын арилжааны зардал /хамгийн өндөр өсөлттэй/, хүүгийн зардал, болзошгүй эрсдэлийн зардал, үндсэн бус үйл ажиллагааны зардал, орлогын татварын зардлууд голлох хувийг эзэлж байна.

Нийт орлогын өсөлт нийт зардлын өсөлт өндөр байгаагаас тайлант оны эцсээр ББСБ-дын татварын дараах ашиг 5.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. ББСБ-ын ашигт ажиллагааны төвшинг илэрхийлсэн активын өгөөж (ROA) системийн дунджаар 4.6 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 5.8 хувь байна.

## В. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн хоршоо /цаашид ХЗХ гэх/-ны үйл ажиллагааны эрх зүйн орчинг тодорхой болгох, төлөвшүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хоршооны гишүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн санхүүгийн боловсрол, мэдлэг, мэдээллийг сайжруулахад чиглэн ажиллалаа.

Хороо тайлант жилд ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг тууштай хамгаалах, гэмт хэргийн шинжтэй, хууль бус үйлдлүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран таслан зогсоох явдал нь иргэдээс зах зээлд алдагдсан итгэлийг сэргээн бататгахад чухал үүрэгтэй тул энэ чиглэлээр үзүүлэх төрийн үйлчилгээг ямар нэгэн хүнд сурталгүйгээр, аль болох шуурхай үзүүлэхэд гол анхаарлаа хандуулсан байна.

ҮИХ-аар хэлэлцэгдэж буй Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөлд мониторинг хийж, Монголын хадгаламж зээлийн хоршоодыг холбоо, Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв зэрэг төрийн бус байгууллагууд болон идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй зарим ХЗХ-д, АХБ болон Канадын хоршоодын холбооны зөвлөхөөс зөвлөгөө авч зохицуулалтыг илүү оновчтой болгох чиглэлээр ажиллалаа.

Хороо нь тайлант хугацаанд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 15 хоршоонд тусгай зөвшөөрлийг шинээр олгосон ба Хоршооны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, журмын нөхцөл шаардлагыг удаа дараа биелүүлээгүй 5 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлсэн ба түдгэлзүүлсэн хугацаанд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй нэр бүхий 11 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоод байна.

Хороо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан 23 ХЗХ-ны хугацааг сунгасан байна.

Шүүхийн шийдвэр болон өөрсдийн хүсэлтээр татан буугдаж байгаа хоршоодын судалгаа, мэдээний тайланг нэгтгэх, Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу шүүхийн шийдвэрээр татан буугдсан 226 хоршоодыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.3 дахь хэсгийг үндэслэн татан буугдсан тухай бичилт хийж, улсын бүртгэлээс хасуулах, Хорооны вэб хуудас болон өдөр тутмын “Зууны мэдээ” сониноор харилцагч иргэд олон нийтэд мэдээллээ.

Улсын бүртгэлд бүртгэлтэй хэдий ч Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, үйл ажиллагаа нь зогсож, санхүү, төлбөрийн чадваргүй болсон Төв Азийн хөрөнгө оруулалт, Зиндаа инвест зэрэг хоршоодын хадгаламж эзэмшигчдийн хохирлыг барагдуулах үйл ажиллагаа, сар бүр гишүүдийн өглөг, авлагын барагдуулалтын тайланг хүлээн авч, хяналт тавих ажиллагаа хийгдэж байна.

Хорооноос ХЗХ-дын үйл ажиллагаанд хийх зайны болон газар дээрх хяналт, шалгалтын ажлыг чангатгах, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Газар дээрх хяналт шалгалтыг ХЗХ-дын санхүү, төлбөрийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаанд нь учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, тооцоолох, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор Хорооны даргын болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу нийт 92 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх үзлэг, шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант онд ХЗХ-дын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтыг тогтмолжуулах, ХЗХ-доос ирүүлсэн улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хянах, илэрсэн дутагдлыг арилгах талаар давхардсан тоогоор 618 тайлангийн хариугаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөж, хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавин ажилласан байна.

ХЗХ-дын ирүүлсэн улирал бүрийн санхүүгийн тайлан, тэнцлийг нэгтгэн, системийн нэгтгэлийг хийж, салбарын статистик дүн шинжилгээ, үнэлэлт, дүгнэлтийг гаргалаа.


### **Зах зээлийн өнөөгийн байдал:**

Хорооноос 2009 оны жилийн эцсийн байдлаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нийт 212 ХЗХ-дын 95 нь Улаанбаатар хотод, 117 нь орон нутагт бүртгэлтэй байна. Нийт хоршоодын 72 нь Хас банкны франчайзын үйлчилгээг авч, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хоршоод юм.

Тайлант онд хоршоодын нийт гишүүдийн тоо 28.1 мянгад хүрсэн байна.

1. **Татсан хадгаламж, олгосон зээл**


ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламж, олгосон зээл



ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 2009 оны жилийн эцсийн байдлаар 29.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны эцсээс 0.6 хувиар, олгосон зээлийн өрийн үлдэгдэл 32.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан байна.

2. **Хоршоодын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа**


Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь /түргэн борлогдох активаас богино хугацаат өр төлбөрийг хасч, гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжид харьцуулж тооцно/ 5 хувиас дээш байхаар зохицуулсан /байвал зохих хувь 7.9/ ба төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 18.9 хувь /бодит хувь/-тай байгаа нь системийн хэмжээгээр бусдад төлөх төлбөрийн нэхэмжлэлийг анхны шаардлагаар гүйцэтгэх чадамжтай байгааг харуулж байна.

### 3. ХЗХ-дын активын бүтэц

ХЗХ-ны системийн нийт активын бүтэц




ХЗХ-дын нийт актив 2009 оны жилийн эцсийн байдлаар 44.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал; чанаргүй зээлийн нийт активт эзлэх хувийн жин 5.3-4.8 хувь, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 4.2-4.7 хувь болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт орлогын хэмжээ 14.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 тэрбум төгрөгөөр буюу 14.4 хувиар, нийт зардлын хэмжээ 12.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 тэрбум төгрөгөөр буюу 17.5 хувиар тус тус өссөнөөс үзэхэд системийн хэмжээнд 1.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарчээ.

### 4. Хоршоодын зээлийн багцын чанар

Зээлийн багцын чанар



Тайлант хугацаанд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар буурч, 32.2 тэрбум төгрөг болсон байна.

Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 тэрбум төгрөг буюу 4.7 хувиар буурч, нийт зээлийн багцын 5.7-6.6 хувийг эзлэх болсон нь зээлдэгчийн төлбөрийн чадвар өмнөх оны мөн үеэс сайжирч байгаатай холбоотой юм.

Зээлийн эрсдэлийн сан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 тэрбум төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн, нийт зээлийн багцад 1.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

### 5. ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламж, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа



ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламж, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа тайлант хугацаанд 19.8 хувь байгаа нь санхүүгийн эх үүсвэрээ гишүүдээс хадгаламж татах замаар өсгөх сонирхол хоршоодод давамгайлж байгаа, тэр утгаараа санхүүгийн эрсдэлд өртөх магадлал нь өндөр хэвээр байгааг харуулж байгаа юм.

Гишүүдээс хоршоонд хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт активын 80 хүртэлх хувь байвал зохистой гэж үздэг бөгөөд энэ үзүүлэлт 67.2 хувьтай байна.

### Г.ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2009 онд даатгалын зах зээл дээр 18 даатгалын компани, 129 даатгалын компанийн салбар, 1676 даатгалын төлөөлөгч, 5 даатгалын зуучлагч, 2 даатгалын хохирол үнэлэгч, 10 актуарч нийт 1840 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явууллаа (Хүснэгт-1).


Хүснэгт-1

**Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчид, тоогоор**

№		2007 он	2008 он	2009 он
1	Даатгагч	15	16	18
2	Даатгалын компанийн салбар	91	120	129
3	Даатгалын төлөөлөгч	690	1 167	1 676
4	Даатгалын зуучлагч	2	4	5
5	Даатгалын хохирол үнэлэгч	-	-	2
6	Актуарч	-	9	10
	<b>БҮГД</b>	<b>798</b>	<b>1 316</b>	<b>1 840</b>

Энэ онд “Нийслэл даатгал” ХХК, “Болор итгэл даатгал” ХХК-иудын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, “Юу ай си даатгал” ХХК, “Соёмбо инк даатгал” ХХК, “Гранд ко даатгал” ХХК-иудад даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

График-1




Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2007 оноос 2009 оны хооронд 2,3 дахин өссөн нь энэхүү зах зээл хэрхэн хурдацтай тэлж байгааг харуулж байна (График-1).

### 1. Даатгагчийн хөрөнгө, өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

2009 оны байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 41,1 тэрбум төгрөгт хүрч өнгөрөгч 2008 оныхоос 19,8 хувиар буюу 6,8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгө нь 2003 онд 12,8 тэрбум төгрөг байсан бол 2005 онд 21,2 тэрбум төгрөг болон өсч, 2006 онд 20,8 тэрбум төгрөг болон буурч байсан бол 2006 оноос хойш тасралтгүй өссөөр 2009 онд 41,1 тэрбум төгрөгт хүрч 2006 оныхтой харьцуулахад 2 дахин өссөн байна (График-2).

График-2


Даатгалын компаниудын нийт хөрөнгө



2009 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын нийт хөрөнгийн 88,3 хувь нь эргэлтийн хөрөнгө, 11,7 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байв. 2003 онд нийт хөрөнгийн 21,1 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байсан бол сүүлийн 6 жилийн туршид нийт хөрөнгө дэх эргэлтийн бус хөрөнгийн хувь тогтвортой буурсан байна (График-3).

График-3

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн харьцаа



■ Эргэлтийн бус хөрөнгө	21.1	20.9	15.6	14.9	14.4	13.7	11.7
■ Эргэлтийн хөрөнгө	78.9	79.1	84.4	85.1	85.6	86.3	88.3

■ Эргэлтийн хөрөнгө      ■ Эргэлтийн бус хөрөнгө

Даатгагчдын нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгийн бүтцийг сүүлийн 4 жилийн байдлаар харахад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр буюу дунджаар 68,7 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт дунджаар 13,6 хувь, дансны авлага дунджаар 9.2 хувь, бусад эргэлтийн хөрөнгө дунджаар 8,6 хувь орчим байсан бөгөөд 2009 онд эргэлтийн хөрөнгөд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хувь буурч харин богино хугацаат хөрөнгө оруулалтын хувь өссөн байна. Гэхдээ “богино хугацаат хөрөнгө оруулалт” гэдэг ойлголтод 3 сараас дээш хугацаатай банкны хадгаламжууд багтдаг учираас эргэлтийн хөрөнгийн дийлэнх хэсгийг мөнгөн хөрөнгө бүрдүүлж байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

**Эргэлтийн хөрөнгийн бүтэц**

сая.төг)

Үзүүлэлтүүд	2006		2007		2008		2009	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12 510.4	70.8	15 600.1	64.3	22 162.2	74.8	23 487.8	64.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1 749.9	9.9	3 065.4	12.6	2 862.2	9.7	7 967.8	22.0
Дансны авлага	1 747.0	9.9	1 979.8	8.2	2 476.0	8.4	3 754.2	10.4
Бусад эргэлтийн хөрөнгө	1 675.2	9.5	3 625.2	14.9	2 131.7	7.2	1 024.9	2.8
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>17 682.5</b>	<b>100.0</b>	<b>24 270.5</b>	<b>100.0</b>	<b>29 632.1</b>	<b>100.0</b>	<b>36 234.7</b>	<b>100.0</b>

Эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь өндөр байгаагийн гол шалтгаан нь Хорооны 2008 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын хэрэгжилттэй холбоотой байна. 2009 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 12.6 тэрбум төгрөгийн хөрөнгө буюу нийт зах зээлийн 30.8 хувийг эзэлж даатгалын салбарыг нийт хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаа бол “Юу ай си даатгал” ХХК 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 1.4 хувийг эзэлж байна (Хүснэгт-3).

Хүснэгт-3

**Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ**

№	Даатгалын компанийн нэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	12 640.0	30.8
2	Бодь даатгал ХХК	3 505.1	8.5
3	Прайм женерал даатгал ХХК	3 162.4	7.7
4	Миг даатгал ХХК	2 804.6	6.8
5	Практикал даатгал ХХК	2 662.5	6.5
6	Ард даатгал ХХК	2 310.7	5.6
7	Номин даатгал ХХК	2 171.2	5.3
8	Түшиг даатгал ХХК	1 728.1	4.2
9	УБ даатгал ХХК	1 306.3	3.2
10	Улаанбаатар хотын даатгал ХХК	1 293.7	3.2
11	Монгол траст холдинг даатгал ХХК	1 190.0	2.9
12	Нэйшнл лайф даатгал ХХК	1 135.7	2.8
13	Ган зам даатгал ХХК	1 101.0	2.7
14	Гранд ко даатгал ХХК	1 000.0	2.4
15	Мөнх даатгал ХХК	976.0	2.4
16	Жонон даатгал ХХК	929.7	2.3
17	Соёмбо инк даатгал ХХК	583.9	1.4
18	Юу ай си даатгал ХХК	554.9	1.4
	<b>ДҮН (Ердийн болон урт хугацааны даатгал)</b>	<b>41 055.8</b>	<b>100.0</b>

Өнгөрөгч 2008 онд “Монгол даатгал” ХХК нийт хөрөнгийн хэмжээгээр нийт зах зээлийн 34,5 хувийг эзэлж байсан бол энэ онд 3,7 пунктээр буурсан нь бусад компаниудын үйл ажиллагаа идэвхжиж байгааг харуулж байна.

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 4 жилийн байдлаар харахад 2005-2007 онуудад эзэмшигчдийн өмч дунджаар 37,2 хувь, нөөцийн сан 56,7 хувь, нийт өр төлбөр 6,1 хувь эзэлж байсан бол 2008 онд энэхүү бүтцэд нилээд өөрчлөлт гарч нөөцийн сан 43,8 хувь болж 18,9 пунктээр буурч, харин нийт өр төлбөр 18,9 пунктээр өссөн байна. Энэ нь Хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн сангийн журам”-ын хавсралтын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэх болсонтой холбоотой байв. Энэхүү “Даатгалын байгууллагын мэдээллийн сангийн журам”-ыг сайжруулан боловсруулж “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам” нэртэйгээр 2009 оны 12 дугаар сарын 275 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү сайжруулан боловсруулсан журмын дагуу орлогод тооцоогүй хураамж нь балансын “нөөц сан” гэсэн үзүүлэлтэд тооцогдох болсон учираас 2009 онд нийт өр төлбөр, эзэмшигчийн өмчид өр төлбөрийн эзлэх хувь өмнөх оныхтой харьцуулахад огцом буурлаа. (График-4).



Эзэмшигчид өмчийн нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид эзлэх хувь 2009 онд 33,9 хувь болж өмнөх 2008 оныхоос 2,9 пунктээр өссөний гол шалтгаан нь 2009 онд даатгалын 3 компани шинээр үүсгэн байгуулагдаж, үүнээс нэг компани нь нэг тэрбум төгрөгийн дүрмийн сантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэнтэй холбоотой байна.

## 2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн орлого

Тайлант хугацаанд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид 25,9 тэрбум төгрөгийн нийт орлого олсон байна. Энэхүү орлогын 98,6 хувийг ердийн даатгалын компаниуд, 1,1 хувийг урт хугацааны даатгалын компани, 0,2 хувийг даатгалын зуучлагч компани, 0,1 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаний орлого бүрдүүлсэн байна.

Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн нийт орлогын 90,3 хувь буюу 23,4 тэрбум төгрөг нь даатгалын нийт хураамжийн орлого, үлдэх хувь нь бусад орлого болон даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн орлого байна. Энэхүү даатгалын нийт хураамжийн орлогын даатгалын үнэлгээ нь 5,9 их наяд төгрөг байсан бөгөөд даатгалын нийт хураамжийн орлогын ерөнхий хандлага нь тасралтгүй өсч байгаа хэдий ч сүүлийн 2 жилд жилийн өсөлтийн хувь хэмжээ буурсан байгааг график-5-аас харж болно.

Даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 25,4 хувийг давхар даатгалд, 0,6 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж 17,3 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Тайлант онд даатгалын нийт хураамжийн орлогын 67,1 хувь буюу 15,7 тэрбум төгрөгийг даатгалын төлөөлөгчөөр, 0,6 хувь буюу 130,5 сая төгрөгийг даатгалын зуучлагчаар дамжуулан олсон байна.

График-5




Тухайн жилд даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр нарийвчлан харахад 27,6 хувь буюу 6,5 тэрбум төгрөг нь хөрөнгийн даатгалаас, 20,4 хувь буюу 4,8 тэрбум төгрөг нь авто тээврийн хэрэгслийн даатгалаас орсон бол урт хугацааны даатгалын эрүүл мэндийн даатгалаар 0,2 хувь буюу 55,4 сая төгрөгийн хураамжийн орлого олжээ. (Хүснэгт-4).

Хүснэгт-4

Даатгалын хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Эзлэх хувь
1.2. Хөрөнгийн даатгал	6 450.4	27.6
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	4 771.4	20.4
1.8. Агаарын хөлгийн даатгал	3 082.9	13.2
1.10. Хариуцлагын даатгал	3 078.6	13.2
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2 676.9	11.4
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1 827.7	7.8
1.11. Санхүүгийн даатгал	611.8	2.6
1.5. Барилга угсралтын даатгал	394.7	1.7
1.4. Ачааны даатгал	375.2	1.6
2.1. Хугацаат амьдралын даатгал	59.5	0.3
2.5. Эрүүл мэндийн даатгал	55.4	0.2
1.7. Мал амьтдын даатгал	13.5	0.1
1.6. Газар тариалангийн даатгал	1.3	0.0
2.3. Хуримтлалын даатгал	0.3	0.0
<b>ДҮН</b>	<b>23 399.6</b>	<b>100.0</b>


Даатгалын салбарын бүтэсэн нэмэгдэл өртөг нь ДНБ-д маш бага хувь эзэлдэг учраас ямар нэг дүгнэлт хийхэд тохиромжтой бус байна. Харин даатгалын нийт хураамжийн орлогыг ДНБ-тэй харьцуулахад 2001 оноос 2009 оны хооронд 0,32 хувиас 0,43 хувийн хооронд хэлбэлзэж байсан байна (График-6). Энэхүү хэлбэлзлийн гол шалтгаан нь даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-д маш бага хувь эзэлдэг учраас бусад салбарын өсөлт бууралтын нөлөөлөлтэй холбоотой.

График-6



2008 онд нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого 7977,6 мянган төгрөг байсан бол энэ онд 8657,1 мянган төгрөг болж 8,5 хувиар өссөн байна. Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого 2005 оноос хойш нилээд хурдацтай өссөн байгааг график-7-гоос харж болохоор байна.

График-7




### 3. Даатгалын нөхөн төлбөр

Тайлант онд даатгалын компаниуд 5,5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22,2 хувиар буюу 1,0 тэрбум төгрөгөөр өссөн байна (График-8).

Даатгалын нөхөн төлбөр

График-8




Тухайн жилд олгосон даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нарийвчилбал авто тээврийн хэрэгслийн даатгал нийт нөхөн төлбөрийн 48,7 хувийг эзэлж байгаа бол үүний дараа хөрөнгийн даатгал 19,4 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 11,6 хувийг эзэлж байна. Харин газар тариалангийн даатгал, мал амьтдын даатгалаар нөхөн төлбөр олгогдоогүй байна (Хүснэгт-5).

Хүснэгт-5

Даатгалын хэлбэр	Нийт нөхөн төлбөр (сая.төг)	Эзлэх хувь
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	2 688.1	48.7
1.2. Хөрөнгийн даатгал	1 070.0	19.4
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	642.9	11.6
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	543.4	9.8
1.11. Санхүүгийн даатгал	330.4	6.0
1.4. Ачааны даатгал	99.6	1.8
1.10. Хариуцлагын даатгал	72.3	1.3
1.8. Агаарын хөлгийн даатгал	52.0	0.9
1.5. Барилга угсралтын даатгал	12.5	0.2
2.1. Хугацаат амьдралын даатгал	11.2	0.2
1.6. Газар тариалангийн даатгал		0.0
1.7. Мал амьтдын даатгал		0.0
<b>ДҮН</b>	<b>5 522.4</b>	<b>100.0</b>


Даатгалын хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөрийг сүүлийн 9 жилийн байдлаар зэрэгцүүлэхэд 2001-ээс 2002 оны хооронд хураамжийн орлого бага зэрэг өсч байхад нөхөн төлбөр буурч, эсрэг чиглэлд байсан бол 2003 оноос олгосон нөхөн төлбөр хураамжийн орлогыг даган өсөх болсон байна. Ингэж өсөхдөө хураамжийн орлогын жилийн өсөлтийн хурдаас нилээд доогуур байсан учраас 2009 он гэхэд хураамжийн орлого, нөхөн төлбөрийн хэмжээ нилээд холдож ирснийг график-9-гоос харж болохоор байна.



**4. Даатгалын хохирол нөхөлтийн төвшин.**

2009 онд даатгалын хохирол нөхөлтийн харьцаа 33,5 хувьд хүрч өмнөх 2008 оныхоос 3,1 пунктээр өссөн боловч 2007 оны төвшнээс 10,3 пунктээр доогуур байна (График-10).

График-10



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн төвшингээр харьцуулахад 2009 оны байдлаар “Номин даатгал” ХХК хамгийн өндөр буюу 46,4 хувь, “Монгол траст холдинг даатгал” ХХК хамгийн бага буюу 1,8 хувьтай байна (Хүснэгт-6). Харин 2009 оны сүүлээр шинээр байгуулагдсан даатгалын компаниудын хувьд нөхөн төлбөр олгоогүй байна.

Хүснэгт - 6

**Даатгалын хохирол нөхөлтийн төвшин**

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн төвшин, хувиар		Өсөлт / бууралт пунктээр
		2008 он	2009 он	
1	Номин даатгал ХХК	52.5	46.4	-6,1
2	Түшиг даатгал ХХК	27.5	42.7	15,2
3	Ард даатгал ХХК	39.5	39.3	-0,2
4	Монгол даатгал ХХК	35.5	37.3	1,8
5	Бодь даатгал ХХК	27.5	34.9	7,4
6	Улаанбаатар хотын даатгал ХХК	21.8	28.1	6,3
7	Мөнх даатгал ХХК	0.1	27.4	27,3
8	Прайм женерал даатгал ХХК	16.9	25.5	8,6
9	Жонон даатгал ХХК	25.8	23.7	-2,1
10	Миг даатгал ХХК	33.7	22.6	-11,1
11	Практикал даатгал ХХК	15.4	21.7	6,3
12	УБ даатгал ХХК	11.7	19.3	7,6
13	Нэйшнл лайф даатгал ХХК		16.4	16,4
14	Ган зам даатгал ХХК	10.8	12.9	2,1
15	Монгол траст холдинг даатгал ХХК	12.6	1.8	-10,8
16	Соёмбо инк даатгал ХХК		0.0	
17	Юу ай си даатгал ХХК		0.0	
18	Гранд ко даатгал ХХК			
	<b>ДҮН</b>	<b>30.4</b>	<b>33.5</b>	<b>3,1</b>

Даатгалын компаниудын 2009 онд олгосон хохирол нөхөлтийн төвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Номин даатгал”, “Ард даатгал”, “Жонон даатгал”, “Миг даатгал”, “Монгол траст холдинг даатгал” ХХК-иудийн хохирол нөхөлтийн төвшин буурч, бусад компаниудынх өссөн байна.


**5. Ашигт ажиллагаа**

Тайлант жилд 2,4 тэрбум төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн онтой харьцуулахад 3 дахин буюу 1,8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2008 онд даатгалын салбар 102,8 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж байсан бол 2009 онд 1,8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан нь нийт эзэмшигчдийн өмчийн 12,8 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд “Практикал даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Прайм генерал даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК, “УБ даатгал” ХХК, “Монгол траст холдинг даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Жонон даатгал” ХХК-иуд хуримтлагдсан ашигтай байж нийт 3,5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бол “Юу ай си даатгал” ХХК, “Соёмбо инк даатгал” ХХК, “Түшиг даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК-иуд нийт 1,7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдлыг бий болгожээ. Уг алдагдлын 76,5 хувь буюу 1,3 тэрбум төгрөгийн алдагдал нь Монгол даатгал компанид хамаарч байна. Энэхүү алдагдалыг тус компани Хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой гэж тайлбарласан байна. (Тодруулбал Тус компани нь 2007 онд нөөцийн санг 8-тын аргаар тооцоходоо зардлыг мөн адил 8-тын аргаар хуваарилж байсан нь 2007 онд зардлыг их хэмжээгээр бууруулж ашигтай ажиллаж байсан) зөрчлийг Хорооноос хийсэн газар дээрх хяналт шалгалтаар илрүүлэн гарсан зардлаа бүрэн оруулж ашиг, алдагдлаа тооцож ажиллахыг үүрэг болгосны дагуу тус компани нь зардлыг бүрэн тооцоолсноор 2008 онд 865,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж үүний 712,5 сая төгрөгийн алдагдал нь тус компанийн өмнөх үеийн хуримтлагдсан алдагдал байна. (Хүснэгт-7).

Хүснэгт-7

	2007 он		2008 он		2009 он	
	Тоо (сая.төг)	эзлэх хувь	Тоо (сая.төг)	эзлэх хувь	Тоо (сая.төг)	эзлэх хувь
Эзэмшигчийн өмч	9 111.6	103.4	10 732.9	101.0	12 141.6	87.2
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	- 303.4	- 3.4	- 102.8	- 1.0	1 779.0	12.8
<b>Эзэмшигчийн өмчийн дүн</b>	<b>8 808.2</b>	<b>100.0</b>	<b>10 630.1</b>	<b>100.0</b>	<b>13 920.6</b>	<b>100.0</b>


Хуримтлагдсан ашиг (алдагдал)



## 6. Даатгалын нөөц сан

Даатгалын нөөцийн сангийн үлдэгдлийг сүүлийн 4 оны байдлаар зэрэгцүүлэхэд тогтвортой өсч байна (График-11). 2009 онд даатгалын нөөцийн сан 24,7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 15,4 хувиар буюу 3,3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График-11



Даатгалын нөөцийн сангийн 66,4 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 33.6 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 0,2 хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц сан эзэлж байна.

## 7. Давхар даатгал

2009 онд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Прайм женерал даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд даатгалын эрсдэлээ давхар даатгаж нийт 6,0 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байна. Тайлант онд төлсөн давхар даатгалын хураамж өмнөх 2008 онтой харьцуулахад 28,0 хувиар буюу 1,3 тэрбум төгрөгөөр өссөн бол 2006 онтой харьцуулахад 2,1 дахин өссөн байна (График-12).

График 12



(2009 онд төлсөн давхар даатгалын нийт хураамжийн 48,3 хувь буюу 2,9 тэрбум төгрөг нь “агаарын хөлгийн даатгал”, 25,0 хувь буюу 1,5 тэрбум төгрөг нь “хариуцлагын даатгал”, 16,7 хувь нь “хөрөнгийн даатгал”-аас бүрдэж байна) (График-13).

График-13



## 8. Даатгуулагчийн тоо

Энэ онд 341738 даатгуулагч даатгуулсны 93,2 хувь нь хувь хүн, үлдэх 6,8 хувь нь хуулийн этгээд байсан байна. Нийт даатгуулсан хувь хүн, хуулийн этгээдүүдийн 20,0 хувь буюу 68,3 мянгыг “УБ даатгал” ХХК, 18.6 хувь буюу 63,7 мянгыг “Монгол даатгал” ХХК даатгасан байна. Нийт даатгуулагчдын 63,3 хувийг 4 даатгалын компани даатгасан байна (Хүснэгт-10).

Хүснэгт-10

№	Даатгалын компанийн нэр	Даатгуулагчийн тоо			
		хувь хүн	хуулийн этгээд	дүн	эзлэх хувь
1	УБ даатгал ХХК	68 138	164	68 302	<b>20.0</b>
2	Монгол даатгал ХХК	57 298	6 395	63 693	<b>18.6</b>
3	Миг даатгал ХХК	45 290	176	45 466	<b>13.3</b>
4	Номин даатгал ХХК	24 399	14 467	38 866	<b>11.4</b>
5	Улаанбаатар хотын даатгал ХХК	26 284	23	26 307	<b>7.7</b>
6	Бодь даатгал ХХК	23 781	233	24 014	<b>7.0</b>
7	Ард даатгал ХХК	16 746	216	16 962	<b>5.0</b>
8	Түшиг даатгал ХХК	13 804	479	14 283	<b>4.2</b>
9	Мөнх даатгал ХХК	13 938	5	13 943	<b>4.1</b>
10	Прайм женерал даатгал ХХК	11 465	661	12 126	<b>3.5</b>
11	Практикал даатгал ХХК	11 153	206	11 359	<b>3.3</b>
12	Ган зам даатгал ХХК	6 293	24	6 317	<b>1.8</b>
13	Нэйшнл лайф ХХК	66	16	82	<b>0.0</b>
14	Жонон даатгал ХХК	0	11	11	<b>0.0</b>
15	Монгол траст холдинг даатгал ХХК	2	3	5	<b>0.0</b>
16	Соёмбо инк даатгал ХХК	0	1	1	<b>0.0</b>
17	Юу ай си даатгал ХХК	0	1	1	<b>0.0</b>
18	Гранд ко даатгал ХХК	0	0	0	<b>0.0</b>
	<b>ДҮН</b>	<b>318 657</b>	<b>23 081</b>	<b>341 738</b>	<b>100.0</b>

2009 онд 16787 даатгуулагч даатгалын нөхөн төлбөр авсан нь нийт даатгуулсан даатгуулагчдын 5,0 хувь болж байна.

#### **Д. ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай болон Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банкнаас бусад хуулийн этгээд, иргэдийн гүйцэтгэж буй төлбөр тооцооны хяналтын асуудал Хорооны зохицуулалтын үйлчилгээнд хамаарч байна.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангуулах асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн ажлын төлөвлөгөө, сурталчилгааны төсвийг батлуулан хуулийг сурталчлах, хууль зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох зорилго бүхий Хорооны мэдээллийн утсыг ажиллуулж, иргэдээс мэдээлэл авах зэрэг ажлыг зохион байгууллаа. Өнгөрсөн хугацаанд нийт 25 иргэдийн мэдээлэлд хариу өгч арга хэмжээ авсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр, эдийн засаг нийгмийн бүх салбарт бараа, ажил, үйлчилгээний үнийг зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль хэрэгжүүлэхэд үүсэх сөрөг дагаварыг багасгах, зохиомлоор дотоодын үнийн өсөлтийг хөөрөгдөхгүй байх, бизнесийн шударга ёс зүйг сахиулахад төрийн эрх бүхий байгууллагууд хамтран ажиллах шаардлагыг харгалзан 9 яамны сайд, Шударга бус өрсөлдөөнийг хянах газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улаанбаатар хот, нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга нарт тоот хүргүүлж, барилгын болон боловсролын салбар дахь гадаад валютаар илэрхийлэгдсэн гэрээ, хэлцэлд шинжилгээ хийх, салбарын дүр төрхийг тодорхойлох, дүгнэлт өгөх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилго бүхий шалгалтын хэсгийг томилж нийт 40 хуулийн этгээд /20 боловсролын байгууллага, 20 барилгын компани/ хамрагджээ.

#### **4. Компанийн засаглалын зарчмыг түгээн сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

Санхүүгийн зохицуулах хороо тайлант жилд тавьсан зорилтынхоо хүрээнд хариуцсан салбаруудын засаглалыг сайжруулах ажлын хүрээнд эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах салбар бүрийн компанийн засаглалын кодексыг улам сайжруулах, шинээр бий болгох зорилт тавин ажиллалаа. Үүнд:

##### **Үнэт цаасны салбарт**

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны дийлэнх хэсэг нь хяналтын багцаас дээш хувийг цөөн тооны томоохон хувьцаа эзэмшигчид эзэмшиж компанийн үйл ажиллагааг удирдаж, хувьцаат компанийг хувийн ганц нэг хүний хөрөнгө мэтээр ашиглах, үнэгүйдүүлэх, ашиггүй мэт харагдуулах, ашиг орлогоос зөвхөн өөрсдөө хүртэх зэрэг үйлдлийг зохицуулах зорилгоор тайлант онд үнэт цаасны зах зээлд дагаж мөрдөж буй эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, хөгжиж буй зах зээлийн шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд Компанийн эрх зүйн байдлыг тодорхой болгох замаар мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, компанийн удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хөрөнгө оруулагчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, ТҮЗ-ийн үүрэг хариуцлагыг өндөрсгөх, бүтэц бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг тодорхой болгох замаар сайн засаглалын практикийг хэвшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр “Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулсан.

Үүний зэрэгцээ үнэт цаас нь нийтэд чөлөөтэй арилжаалагдах хувьцаат компаниудын удирдлага, зохион байгуулалтын тогтвортой бөгөөд зохистой ажиллагааны нөхцлийг бүрдүүлж, улмаар хувьцаа эзэмшигчид болон компани хоорондын итгэлцэл хэвээр хадгалагдаж, тухайн компанийн хөрөнгө оруулалт татах чадвар өсөн нэмэгдэх ач холбогдолтойг харгалзан тус хорооноос батлан гаргаж мөрдүүлж буй “Компанийн засаглалын кодекс”-т Дэлхийн банкны 2009 оны “Монгол Улс дахь компанийн засаглалын үнэлгээний тайлан”-гаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулан баталж, олон нийтэд мэдээлсэн байна.

### **Бичил санхүүгийн салбарт**

Хороо нь бичил санхүүгийн зах зээлийн хөгжил, цаашдын тогтвортой байдлыг хангах, БСБ-уудын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах үүднээс эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох зорилгоор зээлийн хүүгийн төвшин, нөлөөлөх хүчин зүйл, тооцоолол, зээлийн хүүгийн хувь хэмжээг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний судалгаа, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас /Bank for international settlement, WOCCU/ гаргасан эрсдэлийн удирдлагын чиглэлээр мөрдөж буй стандарт, заавар, зөвлөмжийг орчуулж судлах, Монгол улс дахь санхүүгийн түрээсийн харилцаа, хууль эрх зүйн орчин, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн хийж буй гэрээ хэлцлүүд, санхүүгийн түрээсийн харилцааг цаашид хэрхэн зохицуулах, статистик судалгаа, нэгдсэн мэдээлэл, бусад улс орнуудын хяналт, зохицуулалтын талаарх судалгаа хийгдэж байна.

Санхүүгийн салбарын зээлийн эрсдэлийг бууруулах, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг төрөөс дэмжих ажлын хүрээнд “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа эрх зүйн хувьд Банк бус санхүүгийн байгууллага байхаар хуулийн төсөлд тусгаад байна.

Мөн Валютын арилжааны үйл ажиллагаанд оролцогчдыг эрсдэлээс хамгаалах, төрийн зохицуулалтыг оновчтой болгох зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуультай нийцүүлэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, цаашид гадаад валютын арилжааг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий Банк бус санхүүгийн байгууллага эрхэлж байхаар зохицууллаа.

Үүний зэрэгцээ Монголбанкны Зээлийн мэдээллийн санд ББСБ, ХЗХ-дыг Монголбанкны зээлдэгчийн талаарх мэдээлэл цуглуулах шинэ системд зайлшгүй хамруулах зорилгоор Зээлийн мэдээллийн сангийн журмын шинэчилсэн төслийг Монголбанкт хамтран боловсруулж эхлээд байна.

### **Даатгалын салбарт**

Хороо нь Иргэд, даатгуулагчдаас даатгалын зах зээлд итгэх итгэлийг бататгах зорилтыг хэрэгжүүлэн даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ, санхүүгийн чадавхийг нь бэхжүүлэх тал дээр ихээхэн анхаарч “Даатгалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл УИХ-аар батлагдсантай холбогдуулан даатгалын байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг 2010 онд хоёр дахин нэмэгдүүлэх тухай Хорооны шийдвэрийг гарган мөрдөж байна.

Үүний зэрэгцээ даатгалын багц дүрэмд орсон даатгалын журам, заавар, нөхцөл шаардлагуудыг боловсронгуй болгох олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын даатгалын төслийн зөвлөхүүдээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж даатгалын 10 гаруй журам, зааврыг шинэчлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллалаа.

Үүнээс “Даатгалын компаний засаглалын кодекс”-ыг боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гарган мөрдөж байгаа нь тайлант онд хийсэн томоохон ажлуудын нэг юм.

Тайлант хугацаанд шинэчлэн батлагдсан даатгалын журам, зааврыг дагаж мөрдүүлснээр ердийн болон урт хугацааны даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг олон улсын даатгалын зах зээлийн жишиг стандартад нийцүүлэх нөхцөл шаардлага бүрэн хангагдаж, даатгалын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болж сайжирч байгааг дурдахад таатай байна.

## **5. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндсэн гарын авлага боловсруулж хэвлүүлэх, түгээн сурталчлах**

Хороо нь санхүүгийн зах зээлийн хөгжил, цаашдын тогтвортой байдлыг хангахад иргэд, олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд өндөр ач холбогдол өгч 2009 оныг “Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх жил” болгон зарласны дагуу иргэдийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор өөрийн эрхлэх ажлын хүрээнд салбар тус бүрт тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

### **Үнэт цаасны салбарын чиглэлээр:**

1990-ээд оны эхээр хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцааны эзэн болсон олон мянган иргэд эзэмшиж буй хөрөнгийнхөө мөн чанарыг мэдэхгүй буюу дутуу ойлгосноосоо болоод Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд харилцах дансаа нээлгээгүй, нээлгэсэн ч хяналт тавих арга механизмаа бүрэн мэдэхгүй байгаа нь санхүүгийн боловсрол дулимаг байгаатай холбож үзэхээс өөр аргагүй юм.

Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсан цагаасаа эхлэн үнэт цаасны зах зээлийн онцлог, цаашдын хандлага, арга хэрэгслүүдийн талаар анхан, дунд, дээд шатны сургалт, семинар явуулах, хууль эрх зүйн эмхтгэл гаргах, гарын авлага, материал хэвлүүлж тараах зэрэг ажлыг зохион байгуулж, тодорхой арга хэмжээг төлөвлөн ажиллаж ирлээ. Тухайлбал, тайлант онд :

1/ АХБ-тай хамтран Үнэт цаасны зээлийг зохицуулах хууль тогтоомжийн бүрэн эмхтгэл, хөрөнгийн зах зээлийн тухай гарын авлага, ханын зурагт хуудас зэргийг хэвлүүлэн нийслэл болон төв орон нутагт байгууллага, иргэдэд тарааж, сурталчлах;

2/ АХБ-тай хамтран 2 хот, 5 аймагт тусгай хөтөлбөрийн дагуу “Иргэдийн санхүүгийн боловсролд” өдөрлөгийг зохион байгуулж, нийт 416 иргэн хамрагдлаа. Тухайн ажлын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгч, танилцуулга, лавлагаа, зөвлөмжийн эмхтгэлийг тарааж Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийн төлөөлөгч ажиллаж хувьцааны ногдол ашгийн 2.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг өмчлөгч эздэд нь олголоо.

3/ Тайлант онд үнэт цаасны зах зээл дээр ажиллагсад зориулсан семинар, уулзалт-ярилцлагыг мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудал, нийтэд санал болгон үнэт цаас гаргагчид тавих шаардлага, компанийн засаглалын зарчим, хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэрэг асуудлаар зохион байгуулав.

4/ Үнэт цаасны зах зээл дээр ажиллах сонирхолтой иргэдэд анхан шатны мэдлэг олгох сургалтыг Хөрөнгийн биржийн сургалтын төвөөр дамжуулан олгож байгаа бол, үнэт цаасны зах зээл дээр ажиллах мэргэжлийн эрх олгох сургалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулдаг бөгөөд тайлант онд тусгай хөтөлбөрийн дагуу 2 удаа зохион байгуулан 118 хүн хамрагдаж, 108 хүнд үнэт цаасны зах зээл дээр ажиллах эрх олголоо.

**Бичил санхүүгийн чиглэлээр:**

ББСБ, ХЗХ-ны үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор энэ зах зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд Хорооноос авч байгаа бодлогын арга хэмжээнүүд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, зааврууд болон тусгай зөвшөөрөл авсан буюу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон байгууллагын талаар Хорооны цахим-хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж, шаардлагатай тохиолдолд албан тоот хүргүүлэн ажилласан байна.

“Хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт уулзалт-ярилцлагыг 2009 оны 6 дугаар сард Төрийн ордонд Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо, Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвтэй хамтран зохион байгуулж, ХЗХ-д болон бусад төрийн байгууллагуудын төлөөлөл нийт 90 гаруй хүн оролцлоо. Тус уулзалт-ярилцлагаар зөвлөмж гаргаж, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв зэрэг газарт хүргүүлсэн байна.

Тайлант онд ГТХАН-ийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн “Хадгаламж, зээлийн хоршоодын чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодод зориулсан сургалтыг орон нутагт явуулсан.

**Даатгалын салбарын чиглэлээр:**

Даатгал хөгжсөн зах зээлийн орнуудад хүүхэд нялхасаас авахуулан хөгшин буурлууд хүртэл эрүүл мэнд, эд хөрөнгө, үйл ажиллагааныхаа хариуцлагыг даатгалд даатгуулж заншсан буюу бараг 100 хувь даатгалд хамрагддаг бол манай хүн амын дөнгөж дөрөвний нэг нь ямар нэг даатгалын гэрээнд шууд болон шууд бусаар оролцож байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Энэ нь нэг талаас хүн амын орлогын мөнгөн хуримтлал доогуур байгаатай, нөгөө талаас иргэд даатгалын ач холбогдлыг бүрэн ойлгодоггүйтэй холбоотой гэж үзэж болно.

Иймээс иргэдэд даатгалын ач холбогдлыг тайлбарлан ойлгуулах, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлагын учирч болзошгүй эрсдэлээс даатгуулагчдыг хамгаалах ажлыг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн мэдээ, даатгалын салбарын мэдээллийг бүх нийтэд ил тод болгож сонин хэвлэл, олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр болон Хорооны вэб хуудсаар дамжуулан түргэн шуурхай хүргэх, даатгуулагч иргэд, байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, даатгалын зах зээлд оролцогчдод тусалж дэмжих дэс дараатай ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж ирлээ.

Энэ ажлын хүрээнд Хорооны вэб хуудсанд даатгалын компаниудын санхүүгийн үйл ажиллагааны улирлын тайлан тэнцэл, даатгалын салбарын улирлын болон жилийн эцсийн нэгдсэн танилцуулгыг бүрэн эхээр нь тавьдаг болсон бөгөөд даатгалын бүх байгууллагууд жилийн эцсийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээ сонинд нийтлүүлэн олон нийтэд хүргэж эхэллээ.

Тайлант хугацаанд даатгалын салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ болон шийдвэрүүд, баталж мөрдүүлж байгаа журам, зааврууд, түүнчлэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч, тэдгээрийн салбар, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч болон даатгалын актуарчид, даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрх авсан аудиторудын талаарх бүх төрлийн мэдээллийг Хорооны вэб хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.

Тайлант онд Монгол Улсад үндэсний даатгалын байгууллага үүсч хөгжсөний 75 жилийн ой тохиож, энэ ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг Монголын даатгагчдын холбоотой хамтран зохион байгууллаа. Энэ үеэр иргэд, даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор даатгалын албаны хөгжлийн түүх, даатгалын зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт зэрэг сэдвүүдээр илтгэл тавих, сонинд мэндчилгээ болон сурталчилгааны талаарх материал нийтлүүлэхийн зэрэгцээ телевизийн сувгуудаар даатгалын ач холбогдол, даатгалын салбарын тулгамдсан асуудлууд, шинээр нэвтэрч байгаа бичил даатгал болон амьдралын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл цацаж, шууд ярилцлага зохион явууллаа.

Тайлант онд даатгалын салбарын дэд бүтцийг хөгжүүлж даатгалын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын боловсон хүчний мэргэшил, чадавхийг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч Малын индексжүүлсэн даатгал төслийн төлөөлөгчид, даатгалын хохирол үнэлээчид, даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх аудиторруудад зориулсан төрөлжсөн сургалт, семинаруудыг зохион явуулсан.

## 6. ХОРООНЫ 2009 ОНЫ ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлаас Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны тодотгосон төсвөөр урсгал зардлыг 911.1 сая.төг – өөр баталснаас 494.2 сая.төг буюу 54,2 % - ийг улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр, 416.9 сая.төг буюу 45,8 % - ийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр батлагдаж, Монгол улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нэгдсэн төсвийн тухай хуулийн заалтуудын дагуу хэрэгжүүлэн Хорооны үйл ажиллагааг хэвийн жигд тасралтгүй явуулж өмнөө тавьсан зорилтуудыг бүрэн ханган ажиллаж ирлээ. 2009 оны төсвийн урсгал зардлыг 19.9 сая.төг буюу 2,2 % - иар хэмнэж ажилласан.

### Нэг. Үндсэн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрийн талаар.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2006 оны 33 дугаар тогтоолоор “ Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлс тогтоох журам ” батлагдсанаар Хорооны төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчин бий болж, үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлснээр 2009 онд 310.5 сая. төг – ийг төвлөрүүлж, үйл ажиллагааны санхүүжилтийн дансанд 416,9 сая. төг тэгшитгэн үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл : 52,8 % - ийг Даатгалын байгууллагын зохицуулалтын үйлчилгээний хураамж, 8,3 % - ийг Үнэт цаасны үйл ажиллагааны зохицуулалтын хураамж, 38,9 % - ийг ББСБ, ХЗХоршоодын үйл ажиллагааны зохицуулалтын хураамжаас тус тус бүрдсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрээс улсын төсөвт 350.0 сая.төг төвлөрүүлэхээс 350.0 сая.төг буюу 100,0 % төвлөрүүлэн ажиллаа. Төсвийн урсгал санхүүжилтийн орлогын эх үүсвэрээр 494.2 сая.төг санхүүжихээс 476.3 сая.төг – ийн санхүүжилт авч, 96,4 % - ийн гүйцэтгэлтэй гарлаа.

**Хоёр. Үндсэн үйл ажиллагааны зардал санхүүжилтийн талаар.**

Хорооны 2009 оны төсвийн урсгал зардал 911.1 сая. төг – өөр батлагдсанаас гүйцэтгэлээр 891.2 сая.төг - д хүрч , төсвийн урсгал зардлыг 19.9 сая.төг буюу 2,2 % - иар хэмнэсэн байна. Төсвийн урсгал зардлын гүйцэтгэлийн 47,3 % - ийг үндсэн цалин , 5,6 % - ийг унаа хоолны хөнгөлөлт , 5,6 % - ийг нэмэгдэл урамшуулал , 6,4 % - ийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл , 1,1 % - ийг бичиг хэргийн зардал , 1,3 % - ийг тээвэр шатахууны зардал , 7,8 % - ийг шуудан холбооны зардал , 1,0 % - ийг дотоодын албан томилолт , 1,4 % - ийг гадаад томилолтын зардал , 0,4 % - ийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал , 0,03 % - ийг эд хогшил худалдан авах зардал , 0,7 % - ийг урсгал засварын зардал , 0,9 % - ийг төлбөр хураамж болон бусад зардал , 0,2 % - ийг гадаад зочны зардал , 4,1 % - ийг байрны түрээсийн зардал , 1,2 % - ийг мэдээлэл сурталчилгааны зардал , 1,7 % - ийг сургалт , сурталчилгааны зардал , 9,8 % - ийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал , 3,4 % - ийг олон улсын байгууллагын гишүүний татвар тус тус эзэлж байна. Төсвийн батлагдсан урсгал зардал 2,2 % буюу 19.9 сая.төг – өөр хэмнэлттэй гарсан хэдий ч Монгол улсын Сангийн Сайдын 2009 оны 3 – 56 / 1162 тоотоор ирүүлсэн төсвийн зарцуулалтад тавих шаардлагын төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс тодотгон батлагдсан төсвийг зардлын зүйл хооронд шилжүүлэх эрхийг Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосны дагуу тухайн цаг үеийн ажлын шаардлагын дагуу Сангийн Яамны Төрийн сангийн газарт хүсэлтээ уламжлан төсвийн урсгал зардлын хооронд нь зохицуулах асуудлыг хянуулан тохирсноор 98.8 сая.төг – ийн зохицуулалтыг хийсэн.

**Хороо 2010 онд:**

Цаашид тайлант онд дурдагдсан зорилтод ажлуудыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ “Улс орныхоо санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлын баталгаа байна” гэсэн эрхэм зорилтын хүрээнд 2010 оныг “Санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах жил” болгон зарлаж санхүүгийн тогтвортой байдлыг хангах үйлсэд өөрийн тодорхой хувь нэмрийг оруулах болно.

Энэхүү ажлын хүрээнд Хорооны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Үүнд:

- Зохицуулалтын хүрээний салбаруудын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
- Санхүүгийн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих;
- Зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг тогтмолжуулж, чанаржуулан, нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоог сайжруулах;
- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас гаргасан зөвлөмж, стандартыг нэвтрүүлэх замаар эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, сайн засаглалыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Бичил санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын удирдлага, боловсон хүчний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх;

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**